



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/168

Мандалговь

“Эх оронч худалдан авалт, Орон нутгийн
үйлдвэрлэл - 2019” үзэсгэлэн, худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 30 дугаар зүйлийн 30.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2016 - 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.12-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн байгууллагатай холбох, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор “Эх оронч худалдан авалт, Орон нутгийн үйлдвэрлэл-2019” үзэсгэлэн худалдааг 2019 оны 5 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (ХОХБТХ-ийн дарга)
Нарийн бичгийн дарга: Б.Мөнхжаргал (ХХААГ-ын дарга)
Гишүүд:
Д.Энхтуяа (ХОХБТХ-ийн мэргэжилтэн)
Ш.Наран-Эрдэнэ (НБХ-ийн мэргэжилтэн)
Г.Хишигдаваа (ХХҮГ-ын дарга)
Ц.Бумангэрэл (БСУГ-ын дарга)
Ж.Мөнхбаяр (ХХААГ-ын мэргэжилтэн)
Б.Ням (МХАҮТ-ын Дундговь дахь салбарын тэргүүн)
Д.Чандмань (Аймгийн ХААХХолбооны тэргүүн)

Хоёр. Төрийн худалдан авалтад нийлүүлэх боломжтой стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг сурталчлах ажилд нийт сумд, байгууллага, хоршоо, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ж.МӨНХЧУЛУУН

488190461